



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/08

Баянтал сум

Хяналт, шалгалт, үнэлгээ хийх ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/147 дугаар захирамжаар батлагдсан “Баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд явцын хяналт, шалгалт, үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Л.Отгонпүрэв

(Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

С.Оюунтүлхүүр

(Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Н.Мөнгөнцэцэг

(Засаг даргын Тамгын газрын Архив бичиг хэргийн эрхлэгч)

Ш.Шинэбаяр

(Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл

(Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлого, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд явцын хяналт, шалгалт, үнэлгээ хийх удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.2024 оны 05-р сарын 25-ны өдрийн дотор хяналт шалгалт, үнэлгээ хийж,

үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн дарга
(Л.Отгонпүрэв)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *т.м.д.* ХИШИГНЯМ



БАТЛАВ.
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* РХИШИГНЯМ

СУМЫН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ,
ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

2024.05.16

Нэг. Явцын хяналт, шалгалт, үнэлгээний зорилго.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", аймгийн Засаг даргын 2021 оны А/147 дугаар захирамжаар батлагдсан "Баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын баримт бичгүүдийн биелэлтийг бүрэн хангуулахад оршино.

Хоёр. Зорилт

- 2.1. Бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилт, тайлагналт.
- 2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан бараа, тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалт.
- 2.3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, бодлогын зорилт зохих үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах

Гурав. Гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл.

- 3.1. Үйл ажиллагааны хүрээнд 2024 оны эхний хагас жилд хийсэн ажлын талаарх мэдээллийг 10-15 минутад багтаан мэдээлэх.
- 3.2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт.
- 3.3. Сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- 3.4. Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилт
- 3.5. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ
- 3.6. Шилэн дансны хэрэгжилт
- 3.7. Архив бичиг хэргийг стандарт
- 3.8. Хүний нөөц, хувийн хэрэг
- 3.9. Аймаг, сумын Засаг даргын Зөвлөлөөс өгсөн үүргийн биелэлт

3.10. Байгууллагын хог хаягдал, ногоон орчин

3.11. Санхүүгийн анхан шатны баримт

Дөрөв. Хугацаа

2024 оны 05-р сарын 22-ны өдөр

Тав. Хамрах хүрээ

5.1. Соёлын төв

5.2. Эрүүл мэндийн төв

5.3. 4-р Цэцэрлэг

5.4. Ерөнхий боловсролын сургууль

Зургаа. Хяналт, шалгалт, үнэлгээ хийх ажлын хэсэг.

Ажлын хэсгийн дарга:

Л.Отгонпүрэв

(Засаг даргын Тамгын газрын Санхүү
албаны дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

С.Оюунтүлхүүр

(Засаг даргын Тамгын газрын
Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл
хоршооны асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Н.Мөнгөнцэцэг

(Засаг даргын Тамгын газрын
Архив бичиг хэргийн эрхлэгч)

Ш.Шинэбаяр

(Засаг даргын Тамгын газрын
Байгаль орчин хариуцсан
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл

(Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлого, худалдан авах
ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Засаг даргын Тамгын газар